

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Долгорсүрэн

Утас: 261740 Цахим хаяг: Dolgorsurenb@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Амарсанаа

Утас: 261648 Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn

Аудитор: Ж.Мөнхтуул

Утас: 261648 Цахим хаяг: Munkhtuulj@audit.gov.mn

Аудитор: Н.Нямсүрэн

Утас: 261648 Цахим хаяг: Nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/664
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрх зүйн, хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд “Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хууль”-ийн төсөл, “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөл, “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын тухай хууль”-ийн төсөл, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал шинэчлэн батлах тухай хууль”-ийн төсөл, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл, “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-ийн төсөл, “Арилжааны хууль”-ийн төсөл, “Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төсөл, “Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

Харин дээрх хууль тогтоомжийн тухай хуульд заасан төслийн үзэл баримтлал, үр нөлөө зардлын тооцоо, судалгаа хийх ажилд нийт 153,900.0 мянган төгрөгийг яамны бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж ангиллаас зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд яамны мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын төсвийг 1,669,259.4 мянган төгрөгөөр баталсан боловч тус арга хэмжээ хэрэгжээгүйгээс төрийн өмчит хуулийн этгээдэд олгох татаас ангилалд зохицуулалт хийж, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт олгосон байна. Тус санхүүжилтээр эмнэлэг эрүүл мэндийн даатгалын сангаас авах үйл ажиллагааны зардал, цалингийн зардлын дутагдлыг нөхөж, балансын дараа үеийн болон ирээдүйд үүсэж болзошгүй өр төлбөрийг санхүүжүүлэхээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Хууль зүй, дотоод хэргийн яам 2025 онд баталсан төсвийн татаасыг зохицуулалт хийх, тайлант онд олгосон 850,000.0 мянган төгрөгийг суутган тооцож, өөр ангилалд шилжүүлэн зарцуулах эрсдэлийг бий болгосон байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам хөрөнгө оруулалтын барьцааг өмнөх онуудад урьдчилж орсон орлого дансанд бүртгэдэг байсныг аудитын мэргэжлийн шийдлээр бий болсон орлогын шинж чанар агуулаагүй, төсвийн данс хоорондын мөнгөн гүйлгээ тул хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өр төлбөрийн ангилалд тайлант оны гүйцэтгэлийг залруулан бүртгүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Өмнөх онд Хууль зүй, дотоод хэргийн яамны хөрөнгийн зардалд 5,349,400.0 мянган төгрөгийн төсөв баталж, зарцуулсан боловч тайланд онд Монгол Улсын 2024 оны төсвийн хуулиар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хөрөнгийн зардал нийт 127,187,700.0 мянган төгрөг байгаагаас яамны төсвийг 42,331,000.0 мянган төгрөгөөр баталж, хөрөнгө оруулалтын тайланг тусад нь бэлтгэдэггүйгээс аудит гүйцэтгэх цаг хугацаа хязгаарлагдмал байгаагаас бүрэн хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байгаа тул эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хөрөглөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,773,285,928.38	8,817,291,656.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,432,175,763.50	2,963,907,888.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,432,175,763.50	2,963,907,888.50
3121	Төгрөг	2,432,175,763.50	2,963,907,888.50
31211	Төрийн сангийн харилцах	40,799,475.00	99,888,042.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,391,376,288.50	2,864,019,846.50
33	АВЛАГА	254,500.00	355,520.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	355,520.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,340,855,664.88	5,853,028,248.14
354	Хангамжийн материал	1,335,012,801.48	5,847,185,384.74
35410	Бичиг хэргийн материал	52,301,228.39	42,119,986.95
35420	Аж ахуйн материал	533,725,071.11	550,441,026.08
35430	Сэлбэг хэрэгсэл	29,424,800.00	34,419,800.00
35440	Түлш, шатах тослох материал	10,936,560.51	18,554,240.00
35470	Бусад хангамжийн материал	708,625,141.47	5,201,650,331.71
35500	Биологийн хөрөнгө	5,842,863.40	5,842,863.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,641,392,606.78	13,133,309,960.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,641,392,606.78	13,133,309,960.90
392	Биет хөрөнгө	12,223,437,796.80	12,908,250,680.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,948,455,956.02	11,948,455,956.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(795,686,315.11)	(993,300,868.27)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	210,833,333.32	860,958,333.32
39204	Хуримтлагдсан элэгдэл	(105,416,666.64)	(35,797,222.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,416,399,028.92	1,720,836,860.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(960,249,781.06)	(1,019,120,006.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	900,926,995.87	895,117,074.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(391,824,754.52)	(468,899,446.61)
393	Биет бус хөрөнгө	417,954,809.98	225,059,280.30
39301	Програм хангамж	675,616,640.00	665,626,640.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(349,531,110.02)	(532,436,639.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	91,869,280.00	91,869,280.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,414,678,535.16	21,950,601,617.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,391,376,288.50	2,864,019,846.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,391,376,288.50	2,864,019,846.50
413	Өглөг	-	2,667,812,006.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	2,667,812,006.00
41400	Урьдчилж орсон орлого	2,391,376,288.50	196,207,840.50
41430	Барьцаа, дэнчингийн УОО	2,391,376,288.50	196,207,840.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,023,302,246.66	19,086,581,771.04
51	Засгийн газрын хувь оролцоо	14,023,302,246.66	19,086,581,771.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	535,355,550.53	535,355,550.53
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	535,355,550.53	535,355,550.53
512	Хуримтлагдсан үр дүн	13,415,616,974.11	18,478,896,498.49
51210	Өмнөх үеийн үр дүн	14,158,325,970.60	13,415,616,974.11
51220	Тайлант үеийн үр дүн	(742,708,996.49)	5,063,279,524.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,329,722.02	72,329,722.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,414,678,535.16	21,950,601,617.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	43,408,113,661.61	63,310,514,504.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	313,736,992.81	1,249,931,816.47
120	Нийтлэг татварын бус орлого	313,736,992.81	1,249,931,816.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	299,606,992.81	1,146,366,292.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,583,300.00	3,040,291.00
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	212,194,807.59	553,751,889.17
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	39,791,124.82	481,752,742.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,037,760.00	107,821,370.00
120009	Бусад орлого	14,130,000.00	103,565,524.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	43,094,376,668.80	62,060,582,687.92
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,658,483,648.01	58,894,511,510.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,314,794,298.01	17,340,516,660.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	5,343,689,350.00	41,553,994,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,435,893,020.79	3,166,071,177.92
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,402,965,320.79	3,166,001,177.92
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,725,544,904.81	20,997,567,352.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,725,544,904.81	20,997,567,352.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,068,294,296.65	10,344,118,755.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,201,448,812.61	3,984,878,980.39
210101	Үндсэн цалин	1,898,159,500.00	2,335,432,380.51
210102	Нэмэгдэл	547,489,408.15	736,568,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	374,291,924.46	532,465,799.88
210104	Урамшуулал	381,507,980.00	380,412,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	388,850,001.34	481,848,249.03
210201	Тэтгэврийн даатгал	261,101,652.01	328,770,199.80
210202	Тэтгэмжийн даатгал	31,127,588.58	41,502,299.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,557,670.72	17,501,099.56
210204	Ажилгүйдлийн даатгал	6,073,140.03	17,001,199.99
210205	Эрүүл мэндийн даатгал	65,989,950.00	77,073,450.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,720,769.11	114,131,498.15
210301	Гэрэл, цахилгаан	62,989,115.39	58,374,999.20
210302	Түлш, халаалт	41,907,601.88	43,673,599.37
210303	Цэвэр, бохир ус	8,824,051.84	12,082,899.58
2104	Хангамж, бараа материалын зардал	254,195,053.56	319,622,443.26
210401	Бичиг хэрэг	56,743,162.86	112,572,541.44
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	49,691,412.45	50,397,999.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,028,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,760,478.25	154,623,302.03
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,441,394.06	26,079,972.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,862,220.06	1,930,572.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	1,342,700.00
210604	Урсгал засвар	28,579,174.00	22,806,700.00
2107	Томилолт, зочны зардал	367,823,030.06	350,454,590.30
210701	Гадаад албан томилолт	294,111,278.12	287,273,263.30

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210702	Дотоод албан томилолт	29,420,025.00	41,990,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	44,291,726.94	21,191,027.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	466,480,951.96	976,590,020.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	451,811,555.96	940,324,280.51
210803	Даатгалын үйлчилгээ	1,802,497.00	5,626,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,300.00	628,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,985,130.00	28,219,640.00
210807	Газрын төлбөр	686,469.00	1,791,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,241,334,283.95	4,090,513,001.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,408,992,016.79	3,190,096,977.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,782,449.00	74,449,936.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	775,559,818.16	825,966,087.43
212	ТАТААС	5,048,179,500.00	9,772,100,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,048,179,500.00	9,772,100,000.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,048,179,500.00	9,772,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	609,071,108.16	881,348,597.24
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	92,537,758.16	114,028,672.64
213102	Засгийн газрын урсгал шилжүүлэг	92,537,758.16	114,028,672.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	516,533,350.00	751,752,335.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,495,400.00	9,021,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамгуулал	189,487,950.00	210,330,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	83,304,335.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	306,550,000.00	449,096,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,637,589.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,567,589.60
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг - Нэмэлт		70,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	6,682,568,756.80	42,312,947,152.06
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,425,277,753.29	37,249,667,627.68
225010	Үнэ төрбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	250,701,104.99	107,300,103.92
225011	Үнэ төрбөргүй гарсан зардал-Бараа материал	1,830,887,298.30	37,142,367,523.76
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(742,708,996.49)	5,063,279,524.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	45,951,324,811.14	64,836,471,838.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,173,884,828.50	2,774,603,571.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,173,884,828.50	2,774,603,571.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,583,300.00	3,040,291.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,583,300.00	3,040,291.00
120009	Бусад орлого	2,151,301,528.50	2,771,563,280.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	43,777,439,982.64	62,061,868,267.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,700,298,739.00	58,894,511,510.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,356,609,389.00	17,340,516,660.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	5,343,689,350.00	41,553,994,850.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,077,141,243.64	3,167,356,757.22
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	336,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,741,141,243.64	3,167,286,757.22
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,419,281,086.64	20,435,897,501.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,419,281,086.64	20,435,897,501.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,382,039,464.64	9,781,163,324.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,201,448,812.61	3,985,234,500.39
210101	Үндсэн цалин	1,898,159,500.00	2,335,787,900.51
210102	Нэмэгдэл	547,489,408.15	736,568,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	374,291,924.46	532,465,799.88
210104	Урамшуулал	381,507,980.00	380,412,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	388,918,751.34	481,779,499.03
210201	Тэтгэврийн даатгал	261,101,652.01	328,770,199.80
210202	Тэтгэмжийн даатгал	31,127,588.58	41,502,299.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,557,670.72	17,501,099.56
210204	Ажилгүйдлийн даатгал	6,073,140.03	17,001,199.99
210205	Эрүүл мэндийн даатгал	66,058,700.00	77,004,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,720,769.11	114,131,498.15
210301	Гэрэл, цахилгаан	62,989,115.39	58,374,999.20
210302	Түлш, халаалт	41,907,601.88	43,673,599.37
210303	Цэвэр, бохир ус	8,824,051.84	12,082,899.58
2104	Хангамж, бараа материалын зардал	246,698,447.45	253,944,799.79
210401	Бичиг хэрэг	87,599,882.00	88,924,800.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	49,691,412.45	50,397,999.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,028,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	107,407,153.00	112,593,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,050,059.00	48,353,686.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,030,185.00	11,229,286.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,624,700.00	12,123,700.00
210604	Урсгал засвар	29,395,174.00	25,000,700.00
2107	Томилолт, зочны зардал	384,999,853.02	357,696,090.30
210701	Гадаад албан томилолт	298,985,261.72	287,273,263.30
210702	Дотоод албан томилолт	32,675,925.00	41,990,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	53,338,666.30	28,432,527.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,490,319,325.32	1,258,665,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	871,074,929.32	910,118,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,802,497.00	5,626,400.00

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,300.00	628,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,616,560,130.00	340,500,960.00
210807	Газрын төлбөр	686,469.00	1,791,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,478,883,446.79	3,281,357,891.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,412,862,306.79	3,202,264,474.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,021,140.00	79,093,416.10
212	ТАТААС	5,048,179,500.00	9,772,100,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,048,179,500.00	9,772,100,000.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,048,179,500.00	9,772,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	989,062,122.00	882,634,176.54
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	92,537,758.16	114,028,672.64
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	92,537,758.16	114,028,672.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	516,533,350.00	751,752,335.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,495,400.00	9,021,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамгуулал	189,487,950.00	210,330,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	83,304,335.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	306,550,000.00	449,096,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,815,090.99	15,567,589.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,815,090.99	15,567,589.60
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	338,175,922.85	1,285,579.30
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт	338,175,922.85	1,285,579.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,532,043,724.50	44,400,574,337.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,542,190,913.00	43,868,842,212.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,542,190,913.00	43,868,842,212.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,542,190,913.00	43,868,842,212.00
221001	Их засвар	-	5,504,111,816.00
222001	Техник хэрэгсэл,багаж тоног төхөөрөмж	5,475,057,113.00	36,049,883,034.00
223001	Бусад хөрөнгө	-	2,195,168,448.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	67,133,800.00	119,678,914.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,542,190,913.00)	(43,868,842,212.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,989,852,811.50	531,732,125.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	442,322,952.00	2,432,175,763.50
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,432,175,763.50	2,963,907,888.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	535,355,550.53	72,329,722.02	14,158,325,970.60	14,766,011,243.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(742,708,996.49)	(742,708,996.49)
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	535,355,550.53	72,329,722.02	13,415,616,974.11	14,023,302,246.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	5,063,279,524.38	5,063,279,524.38
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	535,355,550.53	72,329,722.02	18,478,896,498.49	19,086,581,771.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,674,537,600.00	58,881,984,211.40	792,553,388.60	98.7
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	59,674,537,600.00	58,881,984,211.40	792,553,388.60	98.7
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	6,730,725,600.00	6,720,818,353.76	9,907,246.24	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,263,707,600.00	2,253,804,354.34	9,903,245.66	99.6
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	3,985,238,500.00	3,985,234,500.39	3,999.61	100.0
Үндсэн цалин	2,335,791,900.00	2,335,787,900.51	3,999.49	100.0
Нэмэгдэл цалин	736,568,100.00	736,568,100.00	-	100.0
Унаа хоолны нэмэгдэл	532,465,800.00	532,465,799.88	0.12	100.0
Урамшуулал	380,412,700.00	380,412,700.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	481,779,500.00	481,779,499.03	0.97	100.0
Тэтгэврийн даатгал	328,770,200.00	328,770,199.80	0.20	100.0
Тэтгэмжийн даатгал	41,502,300.00	41,502,299.68	0.32	100.0
ҮОМШӨ-ний даатгал	17,501,100.00	17,501,099.56	0.44	100.0
Ажилгүйдлийн даатгал	17,001,200.00	17,001,199.99	0.01	100.0
Эрүүл мэндийн даатгал	77,004,700.00	77,004,700.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,131,500.00	114,131,498.15	1.85	100.0
Гэрэл, цахилгаан	58,375,000.00	58,374,999.20	0.80	100.0
Түлш, халаалт	43,673,600.00	43,673,599.37	0.63	100.0
Цэвэр, бохир ус	12,082,900.00	12,082,899.58	0.42	100.0
Хангамж, бараа материалын зардал	253,944,800.00	253,944,799.79	0.21	100.0
Бичиг хэрэг	88,924,800.00	88,924,800.00	-	100.0
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	50,398,000.00	50,397,999.79	0.21	100.0
Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,028,600.00	2,028,600.00	-	100.0
БҮТЭЗүйлс	112,593,400.00	112,593,400.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	124,278,200.00	124,278,200.00	-	100.0
Багаж, техник хэрэгсэл	87,153,800.00	87,153,800.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,123,700.00	12,123,700.00	-	100.0
Урсгал засвар	25,000,700.00	25,000,700.00	-	100.0
Томилолт, зочны зардал	358,578,000.00	357,696,090.30	881,909.70	99.8
Гадаад албан томилолт	287,814,200.00	287,273,263.30	540,936.70	99.8
Дотоод албан томилолт	42,330,300.00	41,990,300.00	340,000.00	99.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	28,433,500.00	28,432,527.00	973.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,307,285,600.00	1,298,354,860.00	8,930,740.00	99.3
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	917,880,100.00	908,970,300.00	8,909,800.00	99.0
Даатгалын үйлчилгээ	5,626,400.00	5,626,400.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	628,000.00	628,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	381,359,400.00	381,338,460.00	20,940.00	100.0
Газрын төлбөр	1,791,700.00	1,791,700.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	105,489,500.00	105,398,906.10	90,593.90	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	26,305,500.00	26,305,490.00	10.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,184,000.00	79,093,416.10	90,583.90	99.9
ТАТААС	9,772,100,000.00	9,772,100,000.00	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,772,100,000.00	9,772,100,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	840,712,000.00	835,071,007.64	5,640,992.36	99.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	114,876,200.00	114,028,672.64	847,527.36	99.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	114,876,200.00	114,028,672.64	847,527.36	99.3
Бусад урсгал шилжүүлэг	725,835,800.00	721,042,335.00	4,793,465.00	99.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,492,000.00	9,021,000.00	471,000.00	95.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	210,330,400.00	210,330,400.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	87,513,400.00	83,304,335.00	4,209,065.00	95.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	418,500,000.00	418,386,600.00	113,400.00	100.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	42,331,000,000.00	41,553,994,850.00	777,005,150.00	98.2
Дотоод эх үүсвэрээр	42,331,000,000.00	41,553,994,850.00	777,005,150.00	98.2
Их засвар	6,031,000,000.00	5,504,111,816.00	526,888,184.00	91.3
Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	36,300,000,000.00	36,049,883,034.00	250,116,966.00	99.3

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,674,537,600.00	58,881,984,211.40	792,553,388.60	98.7
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	3,000,000.00	3,040,291.00	(40,291.00)	101.3
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,000,000.00	3,040,291.00	(40,291.00)	101.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	59,671,537,600.00	58,878,943,920.40	792,593,679.60	98.7
Улсын төсвөөс санхүүжих	59,671,537,600.00	58,878,943,920.40	792,593,679.60	98.7
Удирдах ажилтан	16	16	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	84	84	-	100.0
Үйлчилгээний ажилтан	8	8	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,166,071,177.92		
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	3,166,071,177.92	(3,166,071,177.92)	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,166,001,177.92	(3,166,001,177.92)	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	70,000.00	(70,000.00)	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 530,026.2 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**/мянган төгрөгөөр/**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний өмнөх оны үлдэгдлийг 15,567.6 төгрөг, эхний үлдэгдлийг 41,815.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	57,382.6	1	57,382.6			1	57,382.6		
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд үүссэн барьцаа хөрөнгө 472,643.6 мянган төгрөгийг урьдчилж орсон орлого ангилалд бүртгэсэн	1	472,643.6			1	472,643.6	1	472,643.6		
Дүн	2	530,026.2	1	57,382.6	1	472,643.6	2	530,026.2		

3.2 Аудитаар нийт 52,000.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 15,000.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 37,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**/мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Хууль зүй, дотоод хэргийн яам 2024 оны төсвийн төсөлд 40,000.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэх саналыг хүргүүлж, батлуулсан боловч төсвийг үндэслэлтэй төлөвлөгөөгүй, төсвийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүйгээс оны эцэст бодит	1	37,000.0					1	37,000.0		

гүйцэтгэлтэй уялдуулан 3,000.0 мянган төгрөг байхаар зохицуулалт хийсэн.									
Тайлант онд ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны урьдчилгаа олгох зорилгоор 23 ажилтанд нийт 387,000.0 мянган төгрөгийн тусламж үзүүлснээс ХЗДХС-ын 2021 оны А/287 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн салбарын албан хаагчдад орон сууцны дэмжлэг, тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нийтлэг журам"-д заасан шалгуурыг хангаагүй 1 жил ажиллаагүй ажилтанд 15,000.0 мянган төгрөгийн тусламж олгосон.	1				1	15,000.0			
Хууль зүй, дотоод хэргийн яамны нягтлан бодогч эд хариуцагчид бүртгэлээр тавих дотоод хяналтын чиг үүрэг бүхий ажлын зохион байгуулалт байхгүй тооцоо бодоогүй, жилийн эцсийн бараа материалын тооллогыг дутуу хийсэн, нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан "тасралтгүй байх", "үнэн зөв байх" зарчим алдагдсан, бараа материалын үлдэгдлийг буруу илэрхийлсэн, бараа материалын зарцуулалтыг тухай бүр бүртгэл, тайланд тусгаагүй, анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүйгээс санхүүгийн байдлын тайлангийн бараа материал, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал хүлээн зөвшөөрөлттэй холбоотой данснууд буруу илэрхийлэгдэх эрсдэл бий болсон байна.	1							1	
Хууль зүй, дотоод хэргийн яамны санхүүгийн тайлангийн үндсэн	1						1		

хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 66 төрлийн 753,377.1 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээ хийгээгүй байна.									
Дүн	4	52,000.0			1	15,000.0	2	37,000.0	1

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 асуудалд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж тус тус хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
"Олон улсын хурал зохион байгуулах тухай" Засгийн газрын 2024 оны 158 дугаар тогтоолын дагуу "Зардал гаргах тухай" ХЗДХЯ-ны ТНБД-ын 2024 оны 121 дүгээр тушаалын хавсралтад заасан хурлын арга хэмжээний багц болон үндсэн хурлын танхим, салбар хуралдааны танхимыг түрээслэхдээ харьцуулалтын арга хэрэглэхгүйгээр "Шангри-Ла" ХХК-тай 112,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна	1				1			
ХЗДХС-ын 2021 оны А/287 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн салбарын албан хаагчдад орон сууцны дэмжлэг, тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нийтлэг журам"-ыг "Журамд өөрчлөлт оруулах тухай" ХЗДХС-ын 2023 оны А/350 дугаар тушаалаар өөрчлөн найруулахдаа "Тухай байгууллагад 5 жилээс дээш хугацаагаар ажиллаж буй үндсэн албан хаагч ..." гэснийг "Тухайн байгууллагад 1 жилээс дээш хугацаагаар ажиллаж буй албан хаагч" гэж нэмэлт өөрчлөлт оруулсан нь дэмжлэг,	1						1	

тусламжийг хавтгайруулж олгох нөхцөлийг бүрдүүлж, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах журмын үндсэн агуулгатай нийцэхгүй байна								
Нийт дүн	2				1		1	